

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН
АНУ СУДЛАЛЫН БАГА ХУРАЛ****Н. Ишжамц***

Дэлхий даяар шинэ сэтгэлгээний түвшинд харилцан ойлголцож, хамтран ажиллах, зах зээлийн орчин цагийн боловсронгуй бүтэц, механизм хурдавчлан эзэмших зэрэгтэй уялдаж, өндөр хөгжилтэй АНУ, Япон, Баруун Европын орнуудын амьдрал, хөгжил, түүхэн туршлага, дотоод гадаад бодлогыг нарийвчлан судлах дээр улс орнууд нэн эрчимтэй анхаарч, ихээхэн хүч хөрөнгө гаргах болж байна. Ялангуяа АНУ судлалын асуудал Ази, Номхон далайн бүс нутгийн улс орны анхаарлыг ихэд татаж, улс орон тус бүр өөрийн АНУ судлалыг идэвхжүүлж, тийм судлалгүй нэг нь шинэ судлалтай болж байна.

Энэ оны 5-р сарын 22---25-ны өдрүүдэд БНХАУ-ын Нийслэл Бээжин хотноо «ХХ зууны АНУ ба Ази, Номхон далайн бүс нутаг» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхны далайцтай бага хурал болж, бүс нутгийн 17 улс орны 150 гаруй америк-судлаач эрдэмтэн, мэргэжилтэн оролцлоо. Хятадын талаас АНУ, Японы зарим сан хөмрөгийн дэмжлэгтэйгээр зохиосон тул бага хурлын гол зорилго нь Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын АНУ судлалыг эрчимжүүлж, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн харилцан ойлголцож, хамтран ажиллах явдлыг идэвхжүүлэн, орон тус бүрийн дэвшилт хөгжил, өөрчлөлт шинэчлэлтэд тус дөхөм болох явдал байв. Хурлын нээлт, хаалт, өдөр тутмын үйл ажиллагаа, албан ёсны хүлээн авалт сэлтэд БНХАУ-ын нэрт дипломат Хуан Хуа, гадаад явдлын яамны орлогч сайд, нийгмийн ухааны академийн дэд ерөнхийлөгч оролцож, Бээжин дэх АНУ-ын элчин сайдын яаман дээр хурлын төлөөлөгчдийг урьж, хүлээн авалт хийж байсан зэргээс үзсэн ч тус бага хуралд хичнээн их ач холбогдол өгч байсан нь тодорхой байв.

Бага хурал дээр «Ази, Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын ирээдүйн үүрэг холбогдол», «АНУ ба Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал», «Ази, Номхон далайн бүс нутаг дахь Зөвлөлтийн эдийн засаг, худалдааны харилцааны одоогийн байдал, ирээдүйн төлөв», «II дайнаас хойшхи Энэтхэг дэх Америкийн судлал», «1930— 1937 оны Америкийн улс төрийн зөвлөхүүд ба Хятадын үндэсний үзэлт нууц алба» гэх зэрэг 100-гаад эрдэм шинжилгээний илтгэл тавьж, шилжүүлж хэлэлцэн санал бодлоо чөлөөтэй солилцов.

Бага хурлыг нээж хэлсэн үгэндээ БНХАУ-ын америк судлалын холбооны ерөнхийлөгч Ли Шэнзи бага хурлын зорилго, зорилтыг тодорхойлохын хамт орон тус бүр л АНУ судлалыг хүчтэй хөгжүүлж, тэр чиглэлээр нягт хамтран ажиллахын чухлыг цохон тэмдэглэв. Илтгэл тавьж, үг хэлсэн эрдэмтэд асуудал бүрийг янз бүрээр үзэж, сонин санаа бодол дэвшүүлж байв. Жишээлбэл, дэлхийн олон улсын дунд одоо үед Европын эдийн засгийн хамтын нөхөрлөл, Америк-Канадын бүс, Хятад-Гонконг-Тайванийн бүс гэх зэрэг хэд хэдэн том бүс бий болж, цаашдаа Ази, Номхон далайн эдийн засгийн бүс төлөвшиж Европын эдийн засгийн хамтын нөхөрлөлтэй ойртох төлөвтэй. Хэрэв ЗХУ-д зах зээлийн эдийн засаг амжилттай хөгжиж, Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхитэй оролцвол чухал

* Н. Ишжамц -- Дорнодахин, олон улс судлалын тэргүүлэх ажилтан, ШУА-ийн гишүүн, Монголын АНУ судлалын төвийн тэргүүн

ач холбогдолтой болно. Ази, Номхон далайн бүс нутаг их түргэн хөгжиж, Япон хэмээх техник-эдийн засгийн тэргүүн хөгжилтэй орон бий болсон, мөн Азийн дөрвөн барс гарч ирэв, цаашдын хамтын ажиллагаанд Япон технологороо, Америк хөрөнгө капиталаар, Хятад хүн хүчээр, Зөвлөлт түүхий эдээр түлхүү оролцож ажиллах боломжтой, Америк-Зөвлөлт болон Япон-Америкийн харилцаа зэргийг үндсэнд нь гурван үе шат болгож, 1980-аад оны дунд хүртэлх үеийг сэргөлдөөний үе, 80-аад оны дундаас эцэс хүртэлхийг намжмал байдлын үе, 1989 оноос хойшихийг хамтын ажиллагааны үе хэмээн үзэж болно гэх зэрэг дүн шинжилгээ хийгдэж байв. Гэвч олон эрдэмтэд асуудал шүүмжлэн хэлэлцэх явцад өөр ч бодол санаа илэрхийлэгдэж байсан бөгөөд тэр бүхнийг жигдрүүлж, нэгдсэн үзэл боловсруулан гаргах зорилт тавигдаагүй, эрдэмтэн бүхэн бусдын санаа бодол, түүний үндэслэлтэй тодорхой танилцаад тус бүрдээ өөрийн хувийн дүгнэлт гаргалга хийх ёстой байв. Бага хурлын илтгэлүүдийг сонсоод нийт материалтай нь сайтар танилцахад тийм боломж үндсэндээ бүрдэж байгаа юм.

Бага хурлын их завсарлагаанаар Хятадын Америк судлалын хүрээлэнгийн захирал, англи хэл гаргууд эзэмшсэн дунд насны Зи Жүюн авгай төлөөлөгчдийг найрсгаар урьж, хүрээлэнгийнхээ номын сантай биечлэн танилцуулж ярилцсан явдал үнэхээр чухал болсон юм. Тэнд хятад, англи, герман, франц, япон зэрэг олон хэлээр хэвлэгдсэн дотоод, гадаадын олон янзын эрдэм шинжилгээний сэтгүүл, ном хэвлэл байв. Хэдийгээр захирал даруу зан гаргаж, номын сангаа чамлах нь холгүй байсан боловч дорно дахины улс орон дахь америк судлалын сурвалж, судалгааны материал бааз чухам ямар байвал зохихыг ойлгож санаа авах зүйл мөнгүй их байв.

Тус бага хуралд БНМАУ-ын талаас ШУА-ийн олон улсын судалгааны чиглэлт Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн захирал Ц. Батбаяр, Монголын АНУ судлалын төвийн тэргүүний хувьд миний бие оролцсон. Бид Ази, Номхон далайн бүс нутагт АНУ-ын эзлэх байр суурь, бусад улс орны үүрэг холбогдлын талаар санаа бодлоо товч ярьж, шинэ байгуулагдсан АНУ судлалын төв, түүний зорилго, бүтэц бүрэлдэхүүн, шинжилгээний судлагдахуун зэргийгээ тодорхой танилцуулсан. Бага хурлын төгсгөлийн бүгд хуралдаан дээр дүгнэж хэлсэн үгэндээ салбарын ахлагч Монголд АНУ судлалын төв шинээр байгуулагдаж, Ази, Номхон далайн бүс нутгийн америк судлалын эгнээ бас нэг төвөөр нэмэгдэж бэхжив гэж баяртай мэдэгдэж байв. Монголын АНУ судлалын төвийн төлөөлөгчдийг бага хуралд урьж оролцуулсан, эгнээндээ тийнхүү албан ёсоор багтаан авсан тухай мэдэгдсэн зэрэг нь манай төв олон улсын тавцан дээр нэгэнт албан ёсоор зөвшөөрөгдөн хүлээгдсэн гэсэн үг тул одоо бид АНУ судлалын ажлаа зохих ёсоор идэвхжүүлж, аль болохоор гүнзгийрүүлэн чанаржуулах шаардлагатай болж байна.

Бага хурлын хаалтын дараа Хятадын америк судлалын холбооны ерөнхийлөгч өөрөө бүс нутгийн АНУ судлалын төвийн тэргүүн, дэд тэргүүн нарыг урьж тусгай уулзалт зохион, цаашдын зорилт, хамтын ажиллагааны талаар нийт дундаа санал солилцох сайхан бололцоо олгосон нь нэн оновчтой арга хэмжээ болсон бөгөөд ач холбогдлыг нь зохих ёсоор үнэлж, уулзалтанд оролцогсод баяр талархлаа зүй ёсоор илэрхийлсэн билээ.

Бага Хурал зохион байгуулахад үнэтэй тусламж үзүүлж, манай төвийн үйл ажиллагааг бүрэн дэмжихээ илэрхийлсэн Америкийн Азийн сан хөмрөгийн бүсийн захирал Ш. Северингсхаус, профессор С. Кац, Ф. Вэйкман нарт бас бид гүн талархал илэрхийлэх ёстой.